



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 49

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгө бүртгэх
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 1.6, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн санхүүжилтээр барьж ашиглалтад оруулсан, нийт 2,970,001,045.00 (хоёр тэрбум есөн зуун далан сая нэг мянга дөчин таван) төгрөгийн төсөвт өртөг бүхий хавсралтад заасан, бизнес инкубаторын зориулалт бүхий үл хөдлөх хөрөнгийг Баянхонгор аймгийн орон нутгийн өмчийн "Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Д.Энхбат, Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ч.Мөнхцэцэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үл хөдлөх хөрөнгийг хүлээлцэх ажлыг комисс томилон, холбогдох хууль тогтоомж, журмын дагуу зохион байгуулах;


2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

D:\Huraldaanii material\2018.03.06\togtool\04docx

0001485

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн
49 дугаар тогтоолын хавсралт



“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпораци” орон нутгийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Балансын үнэ
		(төгрөг)
1	Барилга угсралтын ажил	2,312,179,049.00
2	Гадна дулаан, уурын зуухны угсралтын ажил	158,453,932.00
3	Гадна цэвэр ус хангамжийн угсралтын ажил	61,894,419.00
4	Гадна бохир ус хангамжийн угсралтын ажил	39,391,493.00
5	Гадна цахилгаан хангамжийн угсралтын ажил	62,469,236.00
6	Гадна хашааны ажил	112,238,256.00
7	Явган зам, ногоон байгууламж	70,546,979.00
8	Автозам	152,827,681.00
Нийт дүн		2,970,001,045.00
		(хоёр тэрбум есөн зуун далан сая нэг мянга дөчин таван)